

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/147/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БҮРЭН СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН 2022
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Дундманхайдай Аудит" ХХК

Утас: 11-325262 Цахим хаяг: info@dumaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.2 Материаллаг байдал.....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	18
5.1 Төлбөрийн акт.....	18
5.2 Албан шаардлага	18
5.3 Зөвлөмж	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол улсын Ерөнхий аудитор
НББ	Нягтлан бодох бүртгэл



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.02.25 № 01/109
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН БҮРЭН СУМЫН
ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Б.САЙНБАЯР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Бүрэн сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Бүрэн сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Засгийн газрын 2022 оны 107 дугаар "Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай" тогтоол, Засгийн газрын 2022 оны 194 дүгээр "Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" тогтоолоор албан хаагчдын цалинд өөрчлөлт орж нэмэгдсэн байна.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 39 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 87 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

G/Архив/Албан бичиг 2023/ А4
19000186

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>21,299,032.94</u>	<u>111,801,898.56</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	93,100,483.16
312	Банканд байгаа бэлэн мөнгө	00.00	93,100,483.16
3121	Төгрөг	00.00	93,100,483.16
31211	Төрийн сангийн харилцах	00.00	93,100,483.16
33	АВЛАГА	2,577,417.54	00.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,998,543.48	00.00
335	Бусад авлага	578,874.06	00.00
3351	Байгууллагаас авах авлага	478,874.06	00.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	100,000.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	18,721,615.40	18,701,415.40
354	Хангамжийн материал	18,721,615.40	18,701,415.40
35410	Бичиг хэргийн материал	226,100.00	100,550.00
35420	Аж ахуйн материал	4,483,685.40	4,351,925.40
35460	Хүнсний материал	3,365,990.00	1,909,500.00
35470	Бусад хангамжийн материал	10,645,840.00	12,339,440.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>658,934,011.69</u>	<u>641,962,145.01</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	658,934,011.69	641,962,145.01
392	Биет хөрөнгө	614,610,011.69	597,638,145.01
39201	Барилга, байгууламж, орон сууц	653,666,651.53	653,666,651.53
39202	Хуримтлагдсан элэгдэл	-71,341,177.18	-95,258,321.74
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	19,975,660.00	35,285,510.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-10,773,024.97	-13,072,771.65
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	42,812,249.90	41,828,924.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	-24,663,347.59	-29,223,848.03
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,110,000.00	4,110,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-411,000.00
39217	Ном	823,000.00	713,000.00
393	Биет бус хөрөнгө	44,324,000.00	44,324,000.00
39301	Программ хангамж	100,000.00	100,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-100,000.00	-100,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	44,324,000.00	44,324,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>680,233,044.63</u>	<u>753,764,043.57</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>680,233,044.63</u>	<u>753,764,043.57</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	680,233,044.63	753,764,043.57
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	550,953,903.00	550,953,903.00
51101	Өмч: - төрийн	550,953,903.00	550,953,903.00
512	Хуримтлагдсан үр дүн	-83,675,572.70	-10,144,573.76
51210	Өмнөх үеийн үр дүн	-83,675,572.70	-761,331,199.79
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	751,186,626.03
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	212,954,714.33	212,954,714.33
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>680,233,044.63</u>	<u>753,764,043.57</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	342,317,300.00	1,131,877,177.09
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,110,000.00	689,695,177.09
120	Нийтлэг татварын бус орлого	4,110,000.00	689,695,177.09
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,110,000.00	689,695,177.09
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	4,110,000.00	689,695,177.09
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	338,207,300.00	442,182,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,227,600.00	14,526,300.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,227,600.00	14,526,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	28,216,600.00	52,940,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	28,216,600.00	52,940,700.00
1330	Төсвийн захирагчдаас	300,763,100.00	374,715,000.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	300,763,100.00	374,715,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	368,093,946.98	380,394,886.04
21	УРСГАЛ ЗАРДАЛ	368,093,946.98	380,394,886.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	291,364,866.46	361,643,208.42
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	185,413,263.94	211,379,897.04
210101	Үндсэн цалин	172,163,011.77	172,807,206.93
210102	Нэмэгдэл	13,250,252.17	26,790,632.97
210104	Урамшуулал	00.00	11,782,057.14
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,722,077.54	25,545,913.80
210201	Тэтгэврийн даатгал	16,730,028.11	17,223,760.24
210202	Тэтгэмжийн даатгал	1,852,836.36	2,081,278.45
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,482,269.05	1,665,022.58
210204	Ажилгүйдлийн даатгал	310,250.28	413,295.76
210205	Эрүүл мэндийн даатгал	3,346,693.74	4,162,556.77
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,345,852.00	28,261,445.92
210301	Гэрэл, цахилгаан	1,604,858.00	3,891,331.92
210302	Түлш, халаалт	22,787,394.00	23,886,664.00
210303	Цэвэр, бохир ус	2,953,600.00	483,450.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,057,400.00	1,849,110.00
210401	Бичиг хэрэг	268,050.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	864,500.00	1,335,950.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	228,000.00	00.00
210404	Ном, хэвлэл	9,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	104,600.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	583,250.00	00.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	513,160.00
2105	Нормативт зардал	14,653,300.00	52,035,240.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	509,250.00	00.00
210502	Хоол, хүнс	12,599,050.00	52,035,240.00

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,545,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	495,540.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	495,540.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	28,000.00
210702	Дотоод албан томилолт	00.00	28,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	299,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	299,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	37,172,972.98	41,748,161.66
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	656,050.00	6,782,080.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	543,550.00	1,950,330.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	35,973,372.98	33,015,751.66
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	76,729,080.52	18,751,677.62
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,227,600.00	14,422,800.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	9,227,600.00	14,422,800.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	67,501,480.52	4,328,877.62
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	67,501,480.52	4,328,877.62
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-25,776,646.98	751,482,291.05
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	295,665.02
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	295,665.02
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-295,665.02
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-25,776,646.98	751,186,626.03

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>338,207,300.00</u>	<u>442,182,000.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	338,207,300.00	442,182,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,227,600.00	14,526,300.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,227,600.00	14,526,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	28,216,600.00	52,940,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	28,216,600.00	52,940,700.00
1330	Төсвийн захирагчдаас	300,763,100.00	374,715,000.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	300,763,100.00	374,715,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>334,954,300.00</u>	<u>349,081,516.84</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	334,954,300.00	349,081,516.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	258,225,219.48	330,329,839.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	186,719,639.94	210,324,800.03
210101	Үндсэн цалин	171,613,011.77	171,752,109.96
210102	Нэмэгдэл	13,900,252.17	26,790,632.97
210104	Урамшуулал	1,206,376.00	11,782,057.10
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,722,077.54	24,023,593.27
210201	Тэтгэврийн даатгал	16,730,028.11	16,575,656.97
210202	Тэтгэмжийн даатгал	1,852,836.36	1,862,493.52
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,456,080.18	1,489,998.61
210204	Ажилгүйдлийн даатгал	336,439.15	370,468.60
210205	Эрүүл мэндийн даатгал	3,346,693.74	3,724,975.57
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,345,852.00	28,261,445.92
210301	Гэрэл, цахилгаан	1,604,858.00	3,834,237.00
210302	Түлш, халаалт	22,787,394.00	23,293,308.92
210303	Цэвэр, бохир ус	2,953,600.00	1,133,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,597,600.00	103,500.00
210401	Бичиг хэрэг	100,000.00	103,500.00
210402	Тээвэр, шатахуун	250,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	200,000.00	-
210404	Ном, хэвлэл	60,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	297,600.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	690,000.00	-
2105	Норматив зардал	16,417,650.00	50,578,750.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	65,000.00	
210502	Хоол, хүнс	15,502,650.00	50,578,750.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	850,000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	4,495,540.00
210604	Урсгал засвар	500,000.00	4,495,540.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	389,900.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	389,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,922,400.00	12,152,310.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	800,000.00	9,902,550.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,122,400.00	2,249,760.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	76,729,080.52	18,751,677.62
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,227,600.00	14,422,800.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	9,227,600.00	14,422,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	370,748.00	4,328,877.62
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	370,748.00	4,328,877.62
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	67,130,732.52	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	67,130,732.52	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	=	<u>93,100,483.16</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	3,253,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,253,000.00	
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(3,253,000.00)</u>	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	93,100,483.16
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	93,100,483.16

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	550,953,903.00	212,954,714.33	-20,251,499.30	743,657,118.03
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	550,953,903.00	212,954,714.33	-20,251,499.30	743,657,118.03
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
7	Тайлант үеийн үр дүн			-63,424,073.40	-63,424,073.40
8	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	550,953,903.00	212,954,714.33	-83,675,572.70	680,233,044.63
9	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	550,953,903.00	212,954,714.33	-83,675,572.70	680,233,044.63
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-677,655,627.09	-677,655,627.09
11	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	550,953,903.00	212,954,714.33	-761,331,199.79	2,577,417.54
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт			00.00	00.00
13	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт			00.00	00.00
14	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			00.00	00.00
15	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү			00.00	00.00
16	Тайлант үеийн үр дүн			751,186,626.03	751,186,626.03
17	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	550,953,903.00	212,954,714.33	-10,144,573.76	753,764,043.57

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	427,655,700.00	330,226,339.22	97,429,360.78	77.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	427,655,700.00	330,226,339.22	97,429,360.78	77.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	427,655,700.00	330,226,339.22	97,429,360.78	77.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	293,965,600.00	210,324,800.03	83,640,799.97	71.55
210101	Үндсэн цалин	239,960,400.00	171,752,109.96	68,208,290.04	71.58
210102	Нэмэгдэл	50,156,400.00	26,790,632.97	23,365,767.03	53.41
210104	Урамшуулал	3,848,800.00	11,782,057.10	(7,933,257.10)	306.12
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,745,800.00	24,023,593.27	12,722,206.73	65.38
210201	Тэтгэврийн даатгал	24,987,100.00	16,575,656.97	8,411,443.03	66.34
210202	Тэтгэмжийн даатгал	2,939,700.00	1,862,493.52	1,077,206.48	63.36
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,351,800.00	1,489,998.61	861,801.39	63.36
210204	Ажилгүйдлийн даатгал	587,900.00	370,468.60	217,431.40	63.02
210205	Эрүүл мэндийн даатгал	5,879,300.00	3,724,975.57	2,154,324.43	63.36
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,748,000.00	28,261,445.92	486,554.08	98.31
210301	Гэрэл, цахилгаан	2,450,000.00	3,834,237.00	(1,384,237.00)	156.50
210302	Түлш, халаалт	23,313,000.00	23,293,308.92	19,691.08	99.92
210303	Цэвэр, бохир ус	2,985,000.00	1,133,900.00	1,851,100.00	37.99
2105	Норматив зардал	50,580,700.00	50,578,750.00	1,950.00	100.00
210502	Хоол, хүнс	50,580,700.00	50,578,750.00	1,950.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,500,000.00	4,495,540.00	4,460.00	99.90
210604	Урсгал засвар	4,500,000.00	4,495,540.00	4,460.00	99.90
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	962,000.00	389,900.00	572,100.00	40.53
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	962,000.00	389,900.00	572,100.00	40.53
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,153,600.00	12,152,310.00	1,290.00	99.99
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,903,600.00	9,902,550.00	1,050.00	99.99
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,250,000.00	2,249,760.00	240.00	99.99
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	427,655,600.00	380,009,070.00	47,646,530.00	88.86
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	374,714,900.00	374,715,000.00	(100.00)	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	374,714,900.00	374,715,000.00	(100.00)	100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	52,940,700.00	5,294,070.00	47,646,630.00	10.00
132001	Орон нутгийн төсвөөс	52,940,700.00	5,294,070.00	47,646,630.00	10.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	93,100,483.16	(93,100,483.16)	-

62	АЖИЛЛАГСДЫН ТОО	17.00	19.00	(2.00)	111.76
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	8.00	10.00	(2.00)	125.00
620003	Үйлчлэх ажилтан	8.00	8.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	14,526,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	14,526,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	103,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	103,500.00
210401	Бичиг хэрэг	103,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,422,800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,422,800.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	14,422,800.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	14,526,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,526,300.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,526,300.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Бүрэн сумын Хүүхдийн цэцэрлэг нь эрхэм зорилгоо “Хүүхдийн хөгжлийг дэмжих, суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгах, амжилттай суралцахад бүх талын хамтын ажиллагаа, оролцоог хангаж, хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах” гэж тодорхойлсон байна. Тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Анхан шатны боловсрол олгох үйл ажиллагаа

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Засгийн газрын 2022 оны 107 дугаар “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” тогтоол
- Засгийн газрын 2022 оны 192 дугаар “Тогтоол, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” тогтоол
- Засгийн газрын 2022 оны 203 дугаар “Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоол
- Сангийн сайдын 2022 оны 120 дугаар “Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай” тогтоол

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт, дотоод аудитын албанаас тус байгууллагын 2022 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Бүрэн сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь үйл ажиллагааны онцлог, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарттай нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Бүрэн сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 73,531.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		93,100.48	93,100.48
Авлага	2,577.42	-	(2,577.42)
Бараа материал	18,721.62	18,701.42	(20.20)
Үндсэн хөрөнгө	658,934.01	641,962.15	(16,971.86)
Нийт хөрөнгийн дүн	680,233.05	753,764.05	73,531.00
Өглөг			-
Засгийн газрын хувь оролцоо	550,953.90	550,953.90	-
Хуримтлагдсан үр дүн	(83,675.57)	(10,144.57)	73,531.00
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	212,954.72	212,954.72	-
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	680,233.05	753,764.05	73,531.00

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгийн данснуудад байна.

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 93,100.5 мянган төгрөгөөр өссөн нь жилийн эцэст зарцуулаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлээгүйгээс шалтгаалсан байна.

Авлагын дансны үлдэгдэл 2,577.4 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны авлагыг тайлант онд бүрэн барагдуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 16,971.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны хөрөнгийн элэгдлийн зардлаас шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвийн санхүүжилтээр 374,714.9 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 52,940.7 мянган төгрөг, нийт 427,655.6 мянган төгрөгийн эх үүсвэрийг төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 5 зорилтын хүрээнд 39 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 427,655.6 мянган төгрөгийн төсөв баталснаас улсын төсвөөс 374,714.9 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 52,941.7 мянган төгрөгийг төлөвлөжээ.

Төсвийн гүйцэтгэлээр улсын төсвөөс 374,714.9 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 52,940.7 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос урсгал үйл ажиллагаанд 349,081.5 мянган төгрөгийг зарцуулж, 93,100.5 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 344,752.6 мянган төгрөг буюу 77,2 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил 83,640.8 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 486.6 мянган төгрөг, норматив зардал 1.9 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 572.1 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 1.3 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71801-Сургуулийн өмнөх боловсрол				
1.1	81605-Эрүүл мэндийг дэмжих	1,300.00	1,300.00	-	100.00
1.2	81807-Цэцэрлэгийн хүүхдийн хоол	50,580.70	50,578.75	1.95	100.00
1.3	81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	2,023.60	2,023.00	0.60	99.97
1.4	81823-Сурагчийн дүрэмт хувцас	1,300.00	1,300.00	-	100.00
1.5	81834-Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	284,725.50	192,676.19	92,049.31	67.67
1.6	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	34,785.20	33,736.58	1,048.62	96.99
Дүн		374,715.00	281,614.52	93,100.48	75.15

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас 14,526.3 мянган төгрөгийг төвлөрүүлж, хангамж бараа материалын зардалд 103.5 мянган төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг 14,422.8 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэлгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Бүрэн сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний Аудитор Н.Тэмүүжин гүйцэтгэж, чанарын хяналтыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний Чанарын хяналтын менежер Б.Цэвэлмаа, захирал Ж.Бямбажав нар хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Бүрэн сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Дундманхайдай Аудит” ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны батлагдсан төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зардал 374,715.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 5,620.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлаас 75 хувиар буюу 4,215.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагын батлагдсан бүтэц орон тоог хэмнэж, хавсран ажиллаж, үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлыг хэмнэх арга хэмжээ авч ажилласан байна.

Тайлант хугацаанд тэвчиж болох бүх төрлийн зардлыг хэмнэснээр цалин хөлс болон нэмэгдэл урамшил 83,640.8 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 486.6 мянган төгрөг, норматив зардал 1.9 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 572.1 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 1.3 мянган төгрөг, нийт 84,702.7 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 170 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансанд мэдээлбэл зохих 170 мэдээллээс 68 мэдээллийг хугацаандаа, 102 мэдээллийг хугацаа хоцроож, 1 мэдээллийг мэдээлээгүй, цалингийн зардлаас бусад 5 саяас дээш ажил гүйлгээнээс 14,422.8 мянган төгрөгийн 2 ажил гүйлгээг мэдээлээгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй нь: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх;" 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МҮЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар 67,210.7 мянган төгрөгийн 6 алдаа зөрчил илрүүлж, алдаа зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн.

Завсрын аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгахад 5 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, 1 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 16,900.0 мянган төгрөгийн 6 зөрчил илэрснээс 2 албан шаардлага, 431.5 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 3,253.0 мянган төгрөгийн 1 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна. Хэрэгжилт 83,3 хувьтай.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	-	2	-	100.0
Төлбөрийн акт	2	431.5	2	431.5	100.0
Зөвлөмж	2	16,468.5	1	3,253.0	50.0
Нийт дүн	6	16,900.0	5	3,684.5	83.3

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын явцад дараагийн аудитаар анхаарах асуудал илрээгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 14,319.6 мянган төгрөгийн 4 зөрчил илэрснээс, 382.4 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 12,553.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 албан шаардлага хүргүүлж, 1,384.2 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөв.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар 382.4 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоов. Үүнд:

1. Эрхлэгчийн 2022 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн Б/17 дугаар тушаалаар нягтлан бодогч, нярав нарт 1,879.1 мянган төгрөгийн урамшуулалт цалин олгохдоо НДШ, ХХОАТ-ыг суутгалгүй олгосны улмаас 382.4 мянган төгрөгийн цалинг гарт илүү олгосон нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-д " хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МҮЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн илүү олгосон цалинг холбогдох албан хаагчаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Аудитаар 12,553.0 мянган төгрөгийн зөрчил арилгах 2 албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв. Үүнд:

1. Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 30 нэр төрлийн 12,453.0 мянган төгрөгийн биет хөрөнгө, 1 нэр төрлийн 100.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгө тус тус бүртгэлтэй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МҮЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

2. Тайлант оны батлагдсан орон тоо 17, гүйцэтгэлээр 19 орон тоотой ажилласнаар тайлагнасан бөгөөд батлагдсан орон тоог 2-оор хэтрүүлэн ажилласан нь: Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-д "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2-д "чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МҮЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн Батлагдсан орон тоог хэтрүүлэн ажиллахгүй байх, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой

Илрүүлэлт:

Тайлант онд төсвийг бодитой төлөвлөөгүйгээс гэрэл цахилгааны зардлыг 1,384.2 мянган төгрөгөөр батлагдсан төсвөөс хэтрүүлэн, зардал хооронд гүйлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-тай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага д шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Эрхлэгчийн 2022.07.19-ний өдрийн Б/17 дугаар тушаалаар нягтлан бодогч, нярав нарт 1,879.1 мянган төгрөгийн урамшуулалт цалин олгохдоо НДШ, ХХОАТ-ыг суутгалгүй олгосны улмаас 382.4 мянган төгрөгийн цалинг гарт илүү олгосон	1	1,879.1	1	1,879.1			-	-	-	-	-	-
Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 30 нэр төрлийн 12,453.0 мянган төгрөгийн биет хөрөнгө, 1 нэр төрлийн 100.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгө тус тус бүртгэлтэй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй	1	12,553.0			1	12,553.0	-	-	-	-	-	-
Тайлант оны батлагдсан орон тоо 17, гүйцэтгэлээр 19 орон тоотой ажилласнаар тайлагнасан бөгөөд батлагдсан орон тоог 2-оор хэтрүүлэн ажилласан	1	-			1	-	-	-	-	-	-	-
Тайлант онд төсвийг бодитой төлөвлөөгүйгээс гэрэл цахилгааны зардлыг 1,384.2 мянган төгрөгөөр батлагдсан төсвөөс хэтрүүлэн, зардал хооронд гүйлгэн зарцуулсан	1	1,384.2					1	1,384.2				
Дүн	4	14,319.6	1	1,879.1	2	12,553.0	1	1,384.2	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<u>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</u>								
Шилэн дансанд мэдээлбэл зохих 170 мэдээллээс 68 мэдээллийг хугацаандаа, 102 мэдээллийг хугацаа хоцроож, 1 мэдээллийг мэдээлээгүй, цалингийн зардлаас бусад 5 саяас дээш ажил гүйлгээнээс 14,422.8 мянган төгрөгийн 2 ажил гүйлгээг мэдээлээгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй	1	14,422.8	-	-	1	14,422.8		
Дүн	1	14,422.8	-	-	1	14,422.8		

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn